# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 22 өдөр Дугаар А/42 Бөхт

Нийтийн цэвэрлэгээ хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.16, Хог хаягдлын тухай хуулийн 9.4.5, 9.4.12, 10.2.6 дах заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын төвд үйл ажиллагаа явуулж буй бүх албан байгууллага, аж ахуйн нэгж, үйлчилгээний газрууд орчныхоо 50 метр хүртэлх тойрог газар болон хуваарьт нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээг 2024 оны 04 дүгээр сарын 23-нд зохион байгуулахыг албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт даалгасугай.

2. Хэсэг хорооллууд маршрутын дагуу хуваарьт талбайн цэвэрлэгээг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 14:00 цагаас зохион байгуулах.

3. Хэсэг хороолол дах орчны цэвэрлэгээг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 13:00 цагаас зохион байгуулах. Хэсэг хорооллын айл өрхүүд цэвэрлэгээг идэвх санаачлагатай хийж, хогийг гаднаа бөөгнүүлж орхихгүй байх, хуваарьт машинуудад ачиж буулгахыг нийт иргэдэд уриалсугай.

4. Нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний түр орлон гүйцэтгэгч (О.Амгалантөр) Бөхт багийн Засаг дарга (М.Цэвэгдорж) нарт үүрэг болгосугай.

5. Нийтийн цэвэрлэгээг хэсэг хорооллын айл өрхүүдэд зохион байгуулах маршрут хуваарийг 1 дүгээр хавсралтаар, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн цэвэрлэх нийтийн эзэмшлийн талбайг 2 дугаар хавсралтаар тус тус баталсяугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Л.МӨНХБАДРАХ

48240100

Засаг даргын 2024 оны 04дүгээр сарын 22ны
өдрийн А/42дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

| № | ХЭСЭГ ХОРООЛОЛ | ЦЭВЭРЛЭХ МАРШРУТ | | ЦЭВЭРЛЭГЭЭНД ОРОЛЦОГСДЫГ БҮРТГЭХ |
|---|---|---|---|---|
| 1 | Зоог хороолол | Эхлэх цэг | Зүүн хойд хар | Д.Шинэбаяр |
| | | Цэвэрлэх чиглэл | Бойны хашаа, Хайлмагны ам, Хогийн цэг | |
| 2 | Баян, Хийморь хороолол | Эхлэх цэг | Шил адууны хөшөө | Х.Уугандорж |
| | | Цэвэрлэх чиглэл | Баян-Бөхт хорооллын ар, зүчээ Наадмын талбай | |
| 3 | Бөхт хороолол | Эхлэх цэг | Цаг уурын овоо | Э.Сумъяа |
| | | Цэвэрлэх чиглэл | Хуучин фонд, Хийморийн морины хөшөө, Цагаан хад Бөхтийн ус | |
| 4 | Сургууль, Орон сууц, Тойром хороолол | Эхлэх цэг | Морь барианы газар | Т.Мөнхбат |
| | | Цэвэрлэх чиглэл | Цагаан тойром, Хогийн цэг | |
| 5 | Малчин хороолол | Эхлэх цэг | Зүүн бойны хашаа | БОХМ О.Амгалантөр |
| | | Цэвэрлэх чиглэл | Малчин хорооллын зүүн тал, Хогийн цэг | |
| Хяналт тавьж зохион байгуулах | | | | М.Цэвэгдорж |

ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ 04 САРЫН 22-НЫ ӨДРИЙН
А/42 ДУГААР ЗАХИРАМЖИЙН 2 ДУГААР ХАВСРАЛТ

## АЛБАН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ХУВААРЬ

| № | Албан байгууллага, аж ахуйн нэгжийн нэр | Цэвэрлэгээний тойрог | Цэвэрлэгээний хугацаа | Хариуцан цэвэрлэж байх нийтийн эзэмшлийн зам талбай | Цэвэрлэгээний хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | ЕБС | Эзэмшил, өмчлөлийнхөө газраас гадагш 50 метр радиуст цэвэрлэгээ хийнэ. | Нийтийн болон орчны цэвэрлэгээ хийх журамд заасан хугацаагаар буюу сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гаригт | Хойд цэцэрлэгт хүрээлэн | Нийтийн болон орчны цэвэрлэгээ хийх журамд заасан хугацаагаар буюу улирал бүрийн сүүлийн сарын 3 дах долоо хоногийн Пүрэв гаригт |
| 2 | ЗДТГ | | | Морь барианы газрын орчин, тоглоомын талбай | |
| 3 | Хүүхдийн цэцэрлэг | | | Урд цэцэрлэгт хүрээлэнгийн зүүн хэсэг | |
| 4 | Соёлын төв | | | Урд цэцэрлэгт хүрээлэнгийн баруун хэсэг | |
| 5 | Эрүүл мэндийн төв | | | Ангийн хашааны зүүн болон урд хэсэг | |
| 6 | Ирмүүн түшиг ХХК | | | Ангийн хашааны хойд болон баруун хэсэг | |
| 7 | Бусад ААН /Дэлгүүр, ШТС, Банк, Холбоо, Цаг уур, Караоке, Асрал ТББ, Тамхины цэг, Тамхины цэг …/ | | | | |